

Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ : гэрээний үнийн дүнгийн 30 хувь
Гэрээнд заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлнэ.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэр: инженерийн хийцтэй худаг шинээр барих ажил

Тоо хэмжээ: 15 (Арван тав) худаг

Төсөвт өртөг: 600,021,000.0 (Зургаан зуун сая хорин нэгэн мянга)

д/д	Үзүүлэлтүүд	Гүйцэтгэгчийн санал
	Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2010 стандартыг мөрдөнө.	
1.	Уст цэгийн хайгуул, ус ашиглалтын цооног хийц, цооног цэвэршүүлэх, шавхалтын ажил	
1.1	Худаг гаргахаар төлөвлөсөн газарт геофизикийн хайгуулын судалгаа хийж геоцахилгаан зүсэлт гаргаж өрөмдөх цэгийн байршлыг тогтооно.	
1.2	Цооног дахь суултын болон шүүрийн яндан: Өрөмдлөгийн яндангийн эцсийн диаметр: 127мм-ээс багагүй хэмжээтэй байна. Материал: ган болон хуванцар хоолой байх ба ундны усны стандарт хангасан 20-иос доошгүй жил ажиллах нөхцлийг хангахаар тооцно.	
1.3	Цооногоос ус өргөх яндан хоолой: Диаметр 32 мм-с багагүй Материал: ган болон хуванцар яндан хоолой байна.	
1.4	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ нь 10-15мм-ээс томгүй байна.	
1.5	Тунгаагуурын урт: 2 м-ээс багагүй.	
1.6	Худгийн цоногт шавхалт хийж цэвэрлэх: 24 цагаас багагүй.	
1.7	Усны чанарын сорилт авах, шинжилгээ хийлгэх.	
1.8	Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох.	
2.	Худгийн цооногийн ашиглалтын ундарга, тоног төхөөрөмж	
2.1	Худгийн цооногийн ашиглалтын ундарга: Цооногийн ашиглалтын ундрага нь нэг цагт 2м ³ -ээс - 6 м ³ ус өгөх хүчин чадалтай байна.	
2.2	Худгийн ус шахуурга, цахилгаан үүсгүүр нь: Чанарын гэрчилгээтэй, холбогдох олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангасан байна. 2022 оноос хойш үйлдвэрлэгдсэн байх, 1 жилийн баталгаат хугацаа гаргана.	
2.3	Ус шахуургын сонгохдоо усны хэрэгцээ ба ус өргөх түний /өндөр/ хэмжээг харгалзан сонгоно.	
2.4	Цахилгаан үүсгүүр сонгохдоо ус шахуургын хүчин чадалд тохирсон байхаар сонгоно.	
3.	Худгийн барилга, усан сан, мал услах онгоц, талбай	
3.1	Худгийн барилга:	

д/д	Үзүүлэлтүүд	Гүйцэтгэгчийн санал
	Худгийн барилгын дотор багтаамж 18м ³ -ээс багагүй, дотор талдаа усан сан, халаах зуух, цооногоос усан сан, усан сангаас мал услах онгоц руу ус дамжуулах хоолойтой, барилга нь гадна талдаа хаяавчтай, мал услах онгоц талбайтай байна. Барилгын материал: Тоосго, блок, мод зэрэг байна.	
3.2	Мал услах онгоцонд ус хүргэх хоолой нь: 50 мм диаметртэй, гадна талын ханаас 2 м урттай ган хоолойг цонхны доод талд гаргана.	
3.3	Ундны ус авах хоолой нь: 50 мм диаметртэй, ган хоолойг цонхны доод талд гаргасан /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/ байна.	
3.4	Усан сан нь босоо суурьтай, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5м ³ -ээс багагүй багтаамжтай ган усан сан байна. Усан сан нь дээрээ модон тагтай.	
3.5	Мал услах онгоц нь 9 м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр ган яндан хоолой буюу цутгамал төмөр бөстөноор хийгдсэн байна. <ul style="list-style-type: none"> • Мал услах онгоцны ёроол нь ус юүлэх налуутай байна. • Онгоцны адагт үлдэгдэл усыг юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг эргэдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулан гагнана. • Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна. 	
3.6	Мал услах талбай: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: Мал услах онгоцны хоёр талд 1.0 м урттай, 0.5 өргөнтэй цементэн хавтангуудыг суурилуулж, мал услах талбай хийнэ. • Материал: 150 маркаас доошгүй чанартай цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэсэн байна. • Мал услах талбай нь худгийн барилга болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуутай бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхээр хийгдсэн байна. 	
4. Худаг хүлээлгэн өгөх		
4.1	Талбайг цэвэрлэх: /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог гэх мэт/	
4.2	Худаг эзэмшигч малчдад худаг, ус шахуурга, жижиг оврын генератор ажиллуулах, үйлчилгээ хийх, сургалт явуулах.	
4.3	Худгийн паспорт, ашиглалтын зааврыг бэлтгэж, ашиглалтанд хүлээлгэн өгөх	

Тендер оролцогч техникийн даалгаварт заасан хэсэг тус бүрээр саналаа тодорхой тайлбарын хамт, мөн цооногийн хийц зохиомжийн бүдүүрч, цооног гүн, цооног оромдох болон шүүрийн цувааны голч зэрэг үзүүлэлтийг, танилцуулгын хамт ирүүлнэ.

